



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/118

Улаанбаатар хот

“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл”-ийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл байгуулах тухай” А/590 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Салбар зөвлөл байгуулах тухай” А/502 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн хэмжээнд эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, өвчлөл, эндэгдлийг бууруулах, эх хүүхдийн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт, өсвөр үе, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, үр дүнг тооцон ажиллах чиг үүрэг бүхий “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл”-ийг шинэчилж, бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган, үр дүнг танилцуулж ажиллахыг Орон тооны бус салбар зөвлөл (Н.Бямбагэрэл)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2023 оны “Салбар зөвлөл байгуулах тухай” А/200 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2026 оны  
04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/18 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



**“ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ОРОН ТООНЫ  
БУС САЛБАР ЗӨВЛӨЛ”-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Салбар зөвлөлийн дарга:	Засаг даргын Орлогч
Орлогч дарга:	Чингэлтэй Нэгдсэн эмнэлгийн захирал
Гишүүд:	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
	Дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга
	Дүүргийн Боловсролын хэлтсийн дарга
	Дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
	Дүүргийн Статистикийн хэлтсийн дарга
	Дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга
	Чингэлтэй Нэгдсэн эмнэлгийн Эмчилгээ эрхэлсэн орлогч
	Чингэлтэй Нэгдсэн эмнэлгийн Нийгмийн эрүүл мэндийн орлогч
Нарийн бичгийн дарга:	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн Эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн